

БУЛГАН АЙГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024 оны 12 сарын 20 өдөр

№	Түвшин	Салбар/ ТЭЗ / Хөтөлбөрийн	Үр дүн, үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн гүйцэтгэлийн	Тайлбар
						он	түвшин						
1.1	Салбар	БШУЯ	Бага насны хүүхдийн хөгжлийн үнэлгээг 4.4 хувиар нэмэгдүүлнэ.										
1.1.1	Хөтөлбөр	Боловсрол	Ерөнхий боловсролын сургуульд элсэгчдийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээг 4 хувиар нэмэгдүүлнэ.										
1.1.1.1.	Төсөл	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	Цэцэрлэгийн барилга барих	Ашиглалтад орох цэцэрлэг	тоо	2022	3	1	0	1,657.7	1,657.7	100	Булган сумын 4-р цэцэрлэгийн барилгын ажлыг "Их азар" ХХК гүйцэтгэж, улсын комисс хүлээн авч, цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.
	Төсөл			Шинээр эхлүүлэх цэцэрлэг	тоо	2022	1	2	1	3,078.8	1,200	38.9	Рашаант суманд улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 75 ортой цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Артуус" ХХК шалгарч, гэрээ байгуулаж ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын байдлаар барилгын ажлын явц 70 хувьтай байна. Булган суманд улсын төсвийн 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар эхлэх 6-р цэцэрлэгийн барилгын ажил төндөр зарласан боловч гүйцэтгэгч компани шалгарсааргүй үнийн зөрүүтэй байллаас болж 2 удаа буцсан байна. Хэрэгжилт Санхүүжилт шийдвэрлэгдээгүй тул хэрэгжилт хангаадаагүй байна.
	Төсөл		Цэцэрлэгийн барилгын засвар хийх	Засвар хийсэн цэцэрлэг	тоо	2022	2	1	0	500.0	0.0	0.00	Хэрэгжилт 0 хувь
	Төсөл		Гэр цэцэрлэгийг шинэчлэх	Шинэчилсэн гэр цэцэрлэг	тоо	2022	-	2	12	82.1	82.1	100	Улсын төсвийн 82.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Агт, Мород, Сайхан, Хутаг-Өндөр суманд 12 ширхэг үж бүрэн гэр цэцэрлэгийг нийлүүлнэ. Хэрэгжилт
1.1.1.2.	Арга хэмжээ	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	"Шинэ багш" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт	хувь	2022	84	90	70	30.0	20.8	62.4	Багшийн хувь хүний хөгжлийн сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулж 10 гаруй багшийн 500 гаруй цахим болон танхим хосолсон сургалтад давхардсан тоогоор 15000 орчим багш, удирдах ажилтан, албан хаагчид, эцэг, эх, суралцагчийг хамруулав. "Сургуульд суурилсан менежментийн загвар"-ыг БШУЯ, БЕГ, "Шинэ монгол төв"-тэй хамтран үе шаттай хэрэгжүүлж аймгийн хэмжээнд 16 ерөнхий боловсролын сургууль, 1 цэцэрлэгийг хамруулан сургуулийн менежментийн 3-4 загварыг туршин хэрэгжүүлснээр удирдлагын манлайлал, менежмент 2.3 хувь, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 4 хувь, хүүхдийн хөгжил хамгаалал 10.3 хувь ахисан амжилттай байна. Багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд 4 шалгуур 13 үзүүлэлтээр төрийн өмчийн 22 сургуулийн 620 багш, 9212 сурагч хамрагдаж, хөгжлийн I түвшинд 78, II түвшинд 173 буюу нийт багш нарын 40.4 хувь нь ур чадварын мөнгөн урамшуулалд хамрагдлаа. Жил бүр явагддаг "Судлаач багш" эрдэм шинжилгээний хуралд нийт 642 багш оролцоноос 4 багийн 8 багш үндэсний хэмжээнд илтгэлээ хэлэлцүүлж, арга, туршлагаа түгээн дэлгэрүүлж, аймгийн багш нарын "Сайн хичээл" зөвлөгөөнд нийт 5 бүсийн 20 баг оролцож туршлага солилцон шилдгүүдээ шалгаруулсан. Салбарын шилдэг багш, ажилтан шалгаруулж шагнаж урамшуулах ажлын хүрээнд Жининь хотын аялалд 7 албан хаагчийг хамруулж 18.9 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.
	Арга хэмжээ		Багш солилцоо арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээнд хамрагдсан багш	тоо	-	-	30	28	20.0	0.0	0.0	Насан туршийн боловсролыг төвийгшигчлэн гэр цэцэрлэг, суурь сургуульд эрхийн байртай багш, ажилтны солилцооны хөтөлбөрийн хүрээнд боловсролын Ерөнхий газартай хамтран Булган аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн "Бүтээлчээр суралцъя" нэртэй мэргэжлийн хөгжлийн бүлгийн сайн туршлагайг Сэлэнгэ аймагт түгээн дэлгэрүүлсэн. Мөн Хэнтий аймгийн Тэмүүжин цогцолбор сургуулийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн "Суралцагчаа судалъя" нэртэй туршлагаас судалж, Булган аймгийн ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн багш нартай хамтран ажиллаж 3 өдөр туршлага солилцон ажилласны үр дүнд "Сайн байшин" арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. Багш солилцоо арга хэмжээнд нийт 28 багш хамрагдснаар "Сайн байшин" арга зүйг нэвтэрүүлж эхэлсэн. Хэрэгжилт 90 хувь
	Арга хэмжээ		Багш нарт зориулсан сэтгэлзүйн эрүүл мэндийн сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан багшийн эзлэх хувь	хувь	-	-	20	60	10.0	0.0	0.0	Аймгийн хэмжээнд ажиллаж буй 4 сургуулийн сэтгэлзүйчтэй хамтран багш нарт сэтгэлзүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалт хэлэлцүүлгийг Булган сумын 3 дугаар сургууль, Бүрэгхангай сумын сургуулийн нийт 60 багш ажилтанд "Сэтгэлзүйчтэй 7 хоног" үнийн дор зохион байгууллаа. Хэрэгжилт 100 хувь
1.1.1.3.	Арга хэмжээ	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	Дутагдалтай багшийн орон тоог нөхөх арга хэмжээг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, дэмжлэг үзүүлсэн багш	тоо	-	-	2, 5	1.59	50.0	0.0	0.0	Дутагдалтай багшийг нөхөх ажлын хүрээнд МУБИС-тай хамтран 12 оюутан багш дадлагажуулан ажиллуулж, ОХУ-аас орос хэлний багш 1, Улаанбаатар хотоос математикийн 1 багшийг суманд урьж, орон нутгийн төсвийн хөрөнгөөр амьдрах байр, нийгмийн баталгааны асуудлыг шийдвэрлэснээр 2023-2024 оны хичээлийн жилийн багшийн дутагдлыг 100 хувь нөхөж ажиллалаа. Энэхүү ажлын хүрээнд өөр аймагт сумаас шилжин ирж ажиллаж буй 56 багшид тухайн сургуультай хамтран 4 төрлийн дэмжлэгийг үзүүлсэн. Үүнд орон байраар 50, хүнсний дэмжлэгт 6, түлээ түлшээр 2, нэмэгдэл мөнгөн урамшуулалд 1 багшийг хамруулаад байна. Дээрх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 13.8 сая төгрөгийг шийдвэрлэсэн байна. Хэрэгжилт
	Арга хэмжээ		МСҮТ, Насан туршийн боловсролыг дэмжсэн арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2022	-	3	2	15.0	0.9	0.13	Орон нутаг дахь мэргэжлийн болон дээд боловсролын төсөгчийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажил олгогчийг татан оролцуулахаар тракторын механикч, гагнуурчин мэргэжлийн ангийн 27 суралцагчдын дадлага ажлыг 6 ААН-тэй нартай хамтран зохион байгуулснаар 12 суралцагч шууд ажлын байртай болж, нийт суралцагчдын 44 хувь нь ажлын байраар хангагдсан байна. Аймгийн Насан туршийн боловсролын төвөөр дамжуулан боловсрол нөхөн олгох хөтөлбөрт 2023-2024 оны хичээлийн жилд 131 суралцагч хамрагдсан. Багшлах хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр 3 төрлийн 8 удаагийн цахим болон танхимын сургалтад 57 багш хамрагдаж, амьдрах ухааны чиглэлээр давсан урлал, хавтага, даалин, нэмжлэг бүтээгдэхүүн хийх сургалтыг төсвөөс 2.5 сая төгрөг зарцуулан зохион байгууллаа. 2024 онд сургалтын 6 чиглэл, 9 хөтөлбөрийг хэрэгжүүлэн насан туршийн боловсрол олгох сургалтуудад давхардсан тоогоор 14896 мэсэг хамруулсан байна. Хэрэгжилт 70 хувь

	Арга хэмжээ		Бүх төрлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах, урамшуулах	Зохион байгуулсан ажлын тоо, урамшуулсан багш	тоо	-	-	2, 5	1.8	20.0	3.0	15	"Судлаач багш" эрдэм шинжилгээний хурлыг "Хамтын оролцоонд суурилсан байгууллагын менежмент" сэдвээр 3 үе шаттай зохион байгуулж, нийт 642 багш оролцсоноос 4 багийн 8 багш үндэсний хэмжээнд илтгэлээ хэлэлцүүлж, арга туршлагаа түгээн дэлгэрүүлж ажиллалаа. Хэрэгжилт 100 хувь
	Арга хэмжээ		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэшсэн багшийг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш	тоо	2022	38	92	98	5.0	0.00	0.00	2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй 23 хүүхэдтэй ажилладаг багш нарт зориулсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө"-г батлуулан, хүүхдэд гарч буй ахиц өөрчлөлтийг баталгаажуулан багш нарын зөвлөлд улирал тутам ажлаа тайлагнан, холбогдох хууль, журмын дагуу нэмэгдэл цалинг олгож байна. Булган сумын 1 дүгээр сургууль, 2 дугаар цэцэрлэгээр 1 удаа зочлон дэмжлэгийн багийн үйл ажиллагаатай танилцан зөвлөгөө өгсөн. Мөн дэмжлэгийн багийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, сургууль цэцэрлэгийн дэмжлэгийн багийн ажлагч, бага боловсрол хариуцсан сургалтын менежерүүд, цэцэрлэгийн арга зүйчид багш нар боловсролд тэгш хамруулах зөвлөлийн гишүүд нийт 98 хүнийг
1.2	Салбар	БШУЯ	Сурагчдын сурлагын үнэлгээг суурь түвшнээс 5 хувиар ахуйлна										
1.2.1	Хөтөлбөр	Боловсрол	Боловсролын чанарын үзүүлэлтийг 12 хувиар нэмэгдүүлнэ										
1.2.1.1.	Төсөл	Ерөнхий боловсрол хөтөлбөр	Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	Тоног төхөөрөмжийн хангалтын өсөлт	хувь	2022	6.2	8	8.5	200.0	700.0	100	Боловсролын ерөнхий газар шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг хүргүүлснээр II улирлын байдлаар улсын төсвийн 700.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 587 ширхэг зөөврийн компьютер, 184 ширхэг ухаалаг дэлгэцийг нийлүүлж, шаардлагатай сургууль, цэцэрлэгт хүргүүлсэн. Хэрэгжилт 100 хувь
	Төсөл		Сургуулийн барилга барих	Шинээр эхлүүлэх сургууль	тоо	2022	1	2	2	3,607.7	3,600.00	100	Улсын төсвийн 5.06 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэгчээр "Туст эр" констракшн шалгарч, гэрээ байгуулаад байна. Мөн улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Агт сумын сургуулийн барилгын ажлын гүйцэтгэгчээр Даацын цамхаг ХХК шалгарч барилгын суурь цутгах бэлтгэл ажил хийгдэж байна. Хэрэгжилт 90 хувь
	Төсөл		Дотуур байр барих	Ашиглалтад орох дотуур байр	тоо	2022	1	2	2	2,994.1	2,100.00	70.1	Дашинчилэн сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилгын ажлыг Манхан уст ХХК, Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны ажлыг Алтайн бумбат өргөө ХХК гүйцэтгэгчээр ажиллаж барилгыг ашиглалтад
				Шинээр эхлүүлэх дотуур байр	тоо	2022	3	2	1	4,671.7	1,600.00	34.3	Улсын төсвийн 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Хялганат тосгоны сургуулийн барилгын гүйцэтгэгчээр МГБИ ХХК шалгарч гэрээ байгуулан, барилгын суурь цутгах бэлтгэл ажил хийгдэж байна. Булган сумын 3-р сургуулийн дотуур байрны зураг төсвийг хийлгэж, 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд
	Төсөл		Спорт заал барих	Ашиглалтад орох спорт заал	тоо	2022	1	1	0	2,038.5	0.0	0	Могод сумын сургуулийн заалны зураг төсөв хийлгэж, 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд хүргүүлсэн. Хэрэгжилт 30 хувь
	Төсөл		Сургуулийн их засвар хийх	Засвар хийсэн сургуулийн тоо	тоо	2022	2	1	0	500.0	0.0	0	Гурванбулаг сумын сургуулийн байрны их засварын ажил санхүүжилт хийгдээгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна. Хэрэгжилт 30 хувь
1.2.1.2.	Арга хэмжээ	Ерөнхий боловсрол хөтөлбөр	"Шинэ ирээдүй" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт	хувь	2022	80	90	90	252.0	199.3	79.1	Шинэ ирээдүй дэд хөтөлбөрийн 14 арга хэмжээний хүрээнд 338.9 сая төгрөг зарцуулж, давхардсан тоогоор 27044 хүн хамрагдсан. Тухайлбал: Ерөнхий боловсролын сурагчдын дунд "Англи хэл", "Математик", "Монгол хэл-Унших бичиг"-ийн масс олимпиадад нийт давхардсан тоогоор 24540 суралцагч хамрагдсан байна. Улсын төрөлжсөн олимпиадын хоёрын давааг орон нутгийн төсвийн 14.3 сая төгрөгийн санхүүжилтээр 10 судлагдахууны 35 төрлөөр зохион байгуулж, 20 сургуулийн нийт 912 оролцогч өрсөлдөж Улсын олимпиадад 10 сурагч шагналт байрт шалгарлаа. БНСУ-ын Кёниг аймгийн Шинхан Их сургуулийн 20 оюутанд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлгийг үргэлжлүүлэн олголоо. Мөн Хойд бүсийн аймгийн химийн анхдугаар олимпиадыг зохион байгуулж, ОХУ-ын Буриад улсын Улан-Үдэ хотод зохион байгуулагдсан "КВН лиг" урлагийн наадамд 2 багш, 7 сурагчийг оролцуулав. Уулзвар бүсийн математикийн олимпиадыг Рашаант сумын ерөнхий боловсролын сургуульд
	Арга хэмжээ		Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан багш сурагчдыг урамшуулах	Урамшуулал олгосон мөнгөн дүн	сая төгрөг	2022	210	250	0	250.0	0.0	0	Элсэлтийн ерөнхий шалгалтаар өндөр оноо авсан 26 суралцагчид 150.1 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгохоор шийдвэрлэж, 68.9 сая төгрөгийг олгоод байна. Хэрэгжилт 100 хувь
	Арга хэмжээ		Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээний хэрэгжилт	хувь	2022	90	91	70	50.0	0.0	0	Элсэлтийн шалгалтад бэлтгэх ажлын хүрээнд сургууль багш бүр элсэлтийн шалгалтад бэлтгэх төлөвлөгөө гарган, 12 дугаар ангийн сурагчаас ахиц амжилтын судалгааг сар бүр авч зөвлөмж чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Мөн Сорил-2024 урьдчилсан элсэлтийн шалгалтыг Боловсролын үнэлгээний төвтэй хамтран бүсчилсэн хэлбэрээр Дашинчилэн, Хутаг-Өндөр, Булган сумын 1 дүгээр сургуульд зохион байгуулж, 10 судлагдахууны хүрээнд элсэлтийн шалгалт өгөхөөр бүртгүүлсэн нийт сурагчдын 90 хувийг хамруулсан. Үр дүнг боловсруулах багийг томилон ажиллуулж дүгнэлт зөвлөмжийг бичиж сургуулиудад хүргүүлэн цаашид хэрхэн ажиллах чиглэлийг тодруулахыг захир төлөвлөгөө гаргаж ажиллуулсан ажилласан. Хэрэгжилт 90 хувь
	Арга хэмжээ		Масс олимпиад зохион байгуулах	Зохион байгуулсан масс олимпиадын тоо	тоо	2022	4	4	4	30.0	14.3	47.7	Ерөнхий боловсролын II-V ангийн сурагчдын дунд "Математик", "Монгол хэл-Унших бичиг"-ийн масс олимпиадыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, математикийн төрөлд давхардсан тоогоор 278 анги бүлгийн 17264 суралцагч хамрагдсан. Англи хэлний масс олимпиадын I даваанд 30 гаруй бүлгийн 700 суралцагч, II даваанд 10 гаруй бүлгийн 300 гаруй суралцагч хамрагдсан байна. Математикийн хичээлийн олимпиадыг Нэрт математикч Д.Шагдарын нэрэмжит болгон 6 ангилал, 9 төрлөөр 353 оролцогчийг хамруулан зохион байгуулж, 1-3 дугаар байрт шалгарсан 103 багш суралцагчийг урамшуулав. Улсын монгол хэлний анги нийтийн олимпиадад 2 дугаар

	Арга хэмжээ		Шинжлэх ухаан технологи, инновацийг дэмжсэн төслийн сонгон шалгаруулалт зохион байгуулах	Дэмжлэг үзүүлсэн төслийн тоо	тоо	2022	0	2	1	30.0	20.0	80.0	"Шинжлэх ухаан, технологи, инновацийг түгээн дэлгэрүүлэх аян"-ны хүрээнд "Стартап менторшил" сургалтыг Хөдөлмөр халамжийн, үйлчилгээний газартай хамтран зохион байгуулж, 17 гарааны бизнес эрхлэгч, шинэ санаатай залуусыг бизнесийн модулиа хэрхэн хөгжүүлж, идэвхжүүлж улмаар зах зээлд нэвтрүүлэхэд туслах зорилготой сургалтыг зохион байгуулав. Мөн Орхон аймагт зохион байгуулсан "Инновацийн 7 хоног" аян, "Эрдэм хакатон 2024" сургалт, гарааны төсөл шалгаруулах арга хэмжээнд "Шимт будаг" үйлдвэрлэх төсөл, "Эко холимог түлш" төслүүд амжилттай оролцон эхийн 20 байрт шалгарлаа. Мөн инновацийн бүтээгдэхүүн, үзэсгэлэнтэй танилцаж, INNO TALK, Startup networking арга хэмжээнд оролцлоо. "Эко холимог түлш" төслийн үйлдвэрлэл нь барилгын байрыг эхлүүлж, эхийн шатны тоног төхөөрөмжийг авч, бүтээгдэхүүний нөөцийг бэлтгэж байна. Тус төслийн үйл ажилтай Шинжлэх ухаан технологийн сангаас
1.3	Салбар	БШУЯ	Олон улсын хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц мэргэжлийн болон техникийн боловсролтой төгсөгчдийг 3 дахин нэмэгдүүлнэ.										
1.3.1	Хөтөлбөр	Боловсрол	МСҮТ төгсөгчдөөс мэргэжлээрээ ажиллагчдыг 4 хувиар нэмэгдүүлнэ.										
1.3.1.1.	Арга хэмжээ	Мэргэжлийн болон техникийн боловсрол хөтөлбөр	"Мэргэжилтэй ажилтан" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	хувь	2022	0	70	30	0.0	0.0	0.0	Орон нутаг дахь мэргэжлийн болон дээд боловсролын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ажил олгогчийг татан оролцуулахаар тракторын механикч, гагнуурчин мэргэжлийн ангийн 27 суралцагчдын дадлага ажлыг "Дулаан хангай" ХХК, "Улаан буудай эх газар" ХХК, "Би Ди Жи Инженеринг ХХК, "Бурхууд" ХХК, "Хангай охин" ХХК, "Хужир толгой авто засвар" ХХК нартай хамтран зохион байгуулснаар 12 суралцагч ажлын байртай болж, нийт суралцагчдын 44 хувь нь
1.5	Салбар	ЭМЯ	Халдварт болон халдварт бус өвчлөлийг 20 хувиар бууруулна.										
1.5.1	Хөтөлбөр	Эрүүл мэнд	Амьдралын зөв дадал хэвшилтэй иргэдийн тоог 30 хувиар нэмэгдүүлнэ.										
	Арга хэмжээ		Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах	Хамрагдсан иргэдийн тоо	тоо	2022	74017	75000	48978	0.0	0.0	0	Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан нарын эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, эрүүл амьдралын хэвшлийг сурталчлах арга зүйн сургалтыг 7 хоног бүр цахимаар зохион байгуулж, 9 удаагийн сургалтад давхардсан тоогоор 89 нийгмийн эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулжээ. Эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан иргэд, албан байгууллагад эрүүл амьдралын дадал хэвшлийг сурталчилсан 11 төрлийн 14250 санамж, зөвлөмж, зурагт хуудас, гарын авлагыг түгээсэн. "Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах нь" сургалтыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулан, сургалтад 16 сумын 70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн дунд зохион байгуулан, уулзалт, ярилцлага хэлэлцүүлэгийг нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд 57, нэрэмжит сарын аян-10 удаа, иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 261 удаагийн тахимийн сургалтнд 1968 иргэдийг хамруулж, сурталчилгаанд давхардсан 40624 тоогоор иргэнийг хамруулсан. Эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хаяг www.bu.mohs.go.mn болон Булган Эрүүл мэндийн газар нүүр хуудсаар мэдээллийг хүргэн цахим хуудсаар мэдээ, мэдээллийг үнэн зөв хүргэх зорилгоор ЭМБ-д давхардсан тоогоор 112 мэдээллийг цахим хуудсанд байршуулж, 31024 хуу цахим
	Арга хэмжээ		"Эрүүл, идэвхтэй амьдрал" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт	хувь	2022	80	90	90	0.0	0.0	0	2024 онд "Эрүүл идэвхтэй амьдрал" арга хэмжээг 5 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг төлөвлөн 90 хувьтай хэрэгжүүлж байна. "Эрүүл хооллолт-Эрүүл байхын үндэс" сарын аяны хүрээнд 5 байгууллагын 125 албан хаагчдад "Эрүүл зохистой хооллолт", "Тэнцвэртэй хооллолт" сэдвээр сургалт зохион байгуулсан. Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эмч, мэргэжилтнүүдэд "Биеийн өвчний цаадах сэтгэл зүй" сэдвэт сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 122 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Иргэдийн хэрэглээний боловсролын төвтэй хамтран "Эрүүл амьдралын зөв дадал зуршил, сэтгэл зүйн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал" сэдвэт сургалтыг 10 сум тосгоны нийт 800 гаруй төрийн албан хаагчдад зохион байгууллаа. "Өсвөр үеийн хүүхдүүдийн зөв зохистой хооллолт" сэдвэт сургалт мэдээллийг "Өсвөрийн эмч клуб"-ын давхардсан тоогоор 12 сурагчид сургалт явуулж, тэдгээр хүүхдүүдээр дамжуулан 8-12 р ангийн 190 хүүхдэд мэдээлэл хүргэж, "Хүүхдүүдээ усаа ууж хэвшигчгээ" гарын авлага түгээж, цахим хуудсанд мэдээлэл байршуулан сурталчилсан. Аймгийн скаутын сурагчдад "Анхан шатны тусламж үзүүлэх нь", Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 3-5-р ангийн суралцагчдад "Өсвөр насны хооллолт" сэдвээр сургалт зохион байгуулж 108 сурагч, "Өсвөрийн чийг ба өрөөмчлөх"

1.5.1.1.	Арга хэмжээ		"Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт	хувь	2022	60	90	90	0.0	0.0	0	2024 онд "Харшлаас сэргийлэх" арга хэмжээг 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг төлөвлөн 80.0 хувьтай хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд: Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяны хүрээнд Хөвсгөл-Булган-Эрдэнэт чиглэлийн хот хоорондын 85 км улсын чанартай авто зам дагуу хаврын улирлын цэвэрлэгээг төрийн болон төрийн бус байгууллагууд цэвэрлэсэн. Хог ургамлын цэвэрлэгээнд 58 төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгжүүд хуваарьт газраа цэвэрлэлээ. Сууд өмчлөгчдийн холбоо нийт 26 орон сууцны 19-н байрны халгай шарилжийг хадгаж цэвэрлэлээ. Нийтийн эзэмшлийн 10,160 м2 талбайн хог ургамлыг 5 дугаар сараас зэрлэгийн хор цацаж устгал хийж, Цэцэрлэгт хүрээлэнгийн 2,5 га талбайн хайлаас, бургас, голт бор, гүйлс, шар хуйлс, улиас зэрэг модны үр боловсрохоос өмнө тайралт хийн 12705 ширхэг мод тарьж ургуулав. Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн болон бусад мэргэжлийн хичээлийн багш нарт "Харшлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах" сэдэвт мэдээлэл, сургалт зохион байгуулж 75 багшийг хамруулан сургуулийн үдийн цай, дотуур байр, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийн гал тогоонуудын үйл ажиллагаанд 3 удаа хяналт хийж, сургуулийн орчинд хориглосон хүнсний бүтээгдэхүүний 3 төрлийн санамжийг тараасан. Иргэний эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг эмийн холбоотой хамтран 2 удаагийн "Нээлттэй хаалганы өдөр"-ийн арга хэмжээний сурталчилгаанд 145 гаруй иргэнд мэдээлэл хүргэсэн. Харшил өвчнөөр эмчийн хяналтад арьсны харшилтай 121, астматай 218 иргэнд эмийг жороор олгож, эмийн
	Арга хэмжээ	Нийгмийн эрүүл мэнд хөтөлбөр	"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт	хувь	2022	70	90	90	0.0	0.0	0	үйл ажиллагааг төлөвлөн 86.3 хувьтай хэрэгжиж байна. Эдгээрийн үр дүнд жирэмсэн, төрөх, төрсний дараах тусламж үйлчилгээг холбогдох тушаал, стандарт, удирдамжийн дагуу хэрэгжүүлж ажилласнаар эхийн эндэгдэлгүй байна. Нярайн түнхний дутмаг хөгжлийн илрүүлэг шинжилгээнд 84 нярайд хамруулж давтан үзлэгт 12 нярайд хамруулсан. Үүнээс А хэлбэр (түнхний хөгжил гүйцэд)-61, В хэлбэр (физиологийн дутуу хөгжил)-12, D хэлбэр (түнхний үеийн мултралтай)-1 нярайд илрүүлж ЭХЭМҮТ-д шилжүүлсэн. Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийг түшиглэн ажлын байрны дадлага сургалтад 2 сум, 1 тосгон, 1 өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн шинэ залуу 3 эх баригч, 1 их эмчийг сургалтад хамруулсан байна. Нэгдсэн эмнэлгийн урологийн их эмчийг бөөр шээсний замын мэс заслаар мэргэжлүүлэн мэс заслын дурангийн их буран тоног төхөөрөмжөөр хангалаа. ЭМЯ-ны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-ийн эмч нар 2023 онд бүртгэгдсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдлуудад зөвлөн туслах дэмжлэгт хяналт хийн гарсан дүгнэлт, зөвлөмжийг нийт ЭМБ-уудад хүргүүлсэн. Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн зөвлөх эмчтэй хамтран эндэгдлүүдийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, хожимдлыг тодорхойлон ЭМБ-уудад цахимаар тохиолдолд суурилсан сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 48 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдав. ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанаас 7 хоног бүр зохион байгуулж байгаа 11 удаагийн цахим хуралд давхардсан тоогоор нийт ЭМБ-уудаас 305 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан байна. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран "Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээг эрчимжүүлэх нь" сургалтанд
	Арга хэмжээ		"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт	хувь	2022	80	90	90	0.0	0.0	0	Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 4 зорилт, 17 арга хэмжээг 80.0 хувьтай хэрэгжиж байна. Урологийн кабинетаар нийт 772 хүнд үзлэг хийн 499 өвчлөл бүртгэгдсэн. Мэс заслын тасгийн урологийн хэсэгт 42 хүн хэвтүүлэн, 6 хүнд хагалгаа хийж, өдрөөр 23 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Өсвөр насны хөвгүүдэд чиглэсэн 3 сэдвээр 16 постер мэдээлэл бэлтгэн цахим болон цаасан хэлбэрээр хүргэж давхардсан тоогоор 3353 хүнд хүрсэн байна. 2024 онд эрт илрүүлэг үзлэгт нийт 25748 хүн хамрагдсанаас 12178 /47.3 хувь/ эрэгтэйчүүд байна. Хэрэгжилт 90 хувь
	Арга хэмжээ		"Хүрч үйлчилье" арга хэмжээг сумдад зохион байгуулж, аймгийн Засаг даргын нэрэмжит нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт иргэдийг хамруулах	Үзлэг зохион байгуулсан сумдын тоо	тоо	2022	8	16	3	10.0	1.0	10	Аймгийн Засаг даргын баталсан удирдамжаар "Хүүхэд хамгааллыг хамтдаа хөгжүүлье" арга хэмжээний хүрээнд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг нийгмийн салбарын байгууллагуудтай хамтран Могод, Хишиг-Өндөр, Тэшиг, Сайхан, Баян-агт суманд зохион байгуулж, давхардсан тоогоор 1281 иргэнийг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулж умайн хүзүүний өөрчлөлттэй илэрсэн 20 эмэгтэй, уушгины аргаг бөгөөд 1 сүрьеэгийн сэжигтэй 1 тохиолдлыг дээд шатлалд шилжүүлсэн
1.5.1.2.	Арга хэмжээ	Арга хэмжээ	"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийн хүрээнд шүд амны хөндийн үзлэгт 2-18 насны хүүхдүүдийг хамруулж, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Үзлэгт хамрагдвал зохих хүүхдийн хамрагдалт	хувь	2022	63.2	65	43	0.00	0.00	0	Ерөнхий боловсролын сургуулийн 11370 сурагчаас 10233 хүүхдийг хамруулахад 90 хувьд, цэцэрлэгийн 3883 хүүхдээс 3494 урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад 65.8 хувьд шүд цоорох өвчлөл илэрсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдавал зохих хүүхдийн 90.0 хувийг хамруулаад байна. Шүдний өвчлөл илэрсэн хүүхдүүдийн 35 хувийг эмчлээд байна. Хэрэгжилт 90 хувь
				Эмчлэн эрүүлжүүлсэн хүүхэд хамрагдалт	хувь	2022	29.3	40	27.5	10.0	0.0	0	Хишиг-Өндөр, Могод, Бугат, Хялганат, Сэлэнгэ, Бүрээхангай, Сайхан, Баян-Агт сумдад шүд, амны хөндийн явуулын үзлэг зохион байгуулан, шүд цоорох өвчин илэрсэн 704 хүүхдэд шүд авах, 4100 хүүхдэд байнгын шүдний ломбо тавих эмчилгээ хийж, нийт өвчлөл илэрсэн хүүхдийн 35.0 хувийг эмчлэн эгсгэрүүлээд байна. Хэрэгжилт 70 хувь
	Үндсэн үйл ажиллагаа		Сүрьеэ хавьтлыг илрүүлэн, үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах	Зорилтот бүлгийн үзлэг, шинжилгээнд хамрагдалт	хувь	2022	89.1	90	85	0.0	0.0	0	2024 оны 10 сарын байдлаар сүрьеэ өвчтэй 28 хүн идэхтэй хяналтад эмчлэгдэж байгаагийн 69 хавьтлыг хавьтлын үзлэг, цээжний рентген зураг, цэрний шинжилгээ, мантугийн сорилд хамруулсан. Далд хэлбэрийн 9 тохиолдлыг буюу 13.4 хувийг илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Аймгийн хэмжээнд сүрьеэгийн идэхтэй илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, нийт 1300 хүнд цээжний рентген зураг хийгдэж, шаардлагатай 9 хүний цэрэнд ХТН илрүүлэх шинжилгээ хийгдсэн. Мантугийн сорил-42 хүнд тавигдсан байна. Илрүүлэг үзлэгээр уушгины аргаг бөгөөд 1-ийг илрүүлэн

	Үндсэн үйл ажиллагаа		Эрт илрүүлэх үзлэгийг эрчимжүүлэх	Хамрагдалтын өсөлт	хувь	2022	30.3	80	41.7	0.00	0.00	0	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/379 дүгээр тушаалыг баримтлан эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд нийт үзлэгт хамрагдал зохих 61717 иргэдээс 27094 буюу 43.9 хувийг хамруулаад байна. Үзлэг оношилгоог насны ангиллаар нь авч үзвэл: 0-5 насны хүүхэд 75 хувь, 6-17 насны хүүхэд 78.6 хувь, 18-30 насны залуучуудын 18.8 хувь, 31-45 насны хүн амын 26.6 хувь, 46-60 насны 33.9 хувь, 61-ээс дээш насны 34.4 хувийг хамруулсан байна. Эрт илрүүлэг үзлэгээр хавдрын сэжигтэй, хавдрын урьдал, хэсгээр, уйланхай, урагцаг, чулуу, үрэвсэлтэй 624 тохиолдлыг дээд шатлалын эмнэлэгт илгээсэн. Өвчлөл илэрсэн иргэдэд нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө өгч, их эмчийн хяналтад шилжүүлээ. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн өвчлөл уорт боовсруулах замын эмгэг, зүлх судасны эмгэг шээс бэлгийн тогтолцооны
	Арга хэмжээ		"Эрүүл цус-Эрүүл ирээдүй" арга хэмжээний хүрээнд БЗДХ/ХДХВ, элэгний В,С вирус илрүүлэх үзлэг зохион байгуулах	Үзлэг хамрагдсан иргэд	тоо	2022	0	8000	2618	0.00	0.00	0	БЗДХ/ХДХВ илрүүлэх шинжилгээнд нийтдээ 2703 хүнийг хамруулсан. Үүнээс Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсэд болон сайн дурын зөвлөгөө, шинжилгээ өгөх кабинетээр нийтдээ 1620 хүн, урьдчилан сэргийлэх үзлэгээр 511 хүн, жирэмсний хяналтаар 690 жирэмсэн эхийг БЗДХ илрүүлэх шинжилгээнд хамруулсан. Элэг бүтэн Монгол, Эрт илрүүлэг үзлэг, оношлогоонд 2176 иргэнд гепатитын В,С вирусийн халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулсан. Хэрэгжилт 90 хувь.
1.5.1.3.	Үндсэн үйл ажиллагаа		В вирус гепатитийн эсрэг 24 цагийн дархлаажуулалт хийх	Дархлаажуулалтад хамрагдалт	хувь	2022	97.5	100	95.5	0.00	0.00	0	2024 оны 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд 393 эх төрж, 393 нярай амьд төрсөн. Шинэ төрсөн нярайн 98.7 хувийн 24 цагт багтаан, В вирусийн эсрэг дархлаажуулалт хамруулсан байна. Хэрэгжилт 100 хувь.
			Тавт дархлаажуулалтыг нэмэгдүүлэх	Дархлаажуулалтад хамрагдалт	хувь	2022	94.7	97.7	96.1	0.00	0.00	0	Тавт вакцины 3-р тунгийн хамрагдалт 98.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хэрэгжилт 100 хувь.
			Улаан бурхан-гахайн хавдар-улаануудын эсрэг дархлаажуулалтыг нэмэгдүүлэх	Дархлаажуулалтад хамрагдалт	хувь	2022	85.4	91.2	94.4	0.00	0.00	0	УГУ эсрэг дархлаажуулалтын хамрагдалт 97.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хэрэгжилт 100 хувь.
1.5.1.4.	Төсөл	Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөр	Дашинчилэн сумын ЭМТ-ийн шинэ барилга барих	Барилгын ажлын гүйцэтгэл	хувь	-	-	50	50	6,203.0	3,102.0	50	Азийн хөгжлийн банк, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2025 онд баригдах Дашинчилэн сумын 15 ортой жишиг Эрүүл мэндийн төвийн барилгын ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна. Нийт төсөвт өртөг 6.9 тэрбум төгрөг үүнээс орон нутгийн төсвөөс 602.0 сая төгрөгийн /Дулаан хангамж, цахилгаан хангамж, цэвэр ус, бохир ажил хийгдэж байна. Хэрэгжилт 100 хувь.
	Төсөл		Бүрэгхангай сумын ЭМТ-ийн шинэ барилга барих	Барилгын ажлын гүйцэтгэл	хувь	-	-	50	0	0	0	0	Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 10 ортой шинэ барилгын ажлын зураг төсвийн дүн 4,590.4 сая төгрөгийг шийдвэрлүүлэх саналыг 2025 оны улсын төсвийн саналд тусгасан. Хэрэгжилт 30 хувь.
	Төсөл		Эрүүл мэндийн байгууллагуудыг түргэн тусламжийн автомашинаар хангах	Түргэн тусламжийн автомашины хангалт	хувь	2022	90	90	100	280.0	261.6	90	2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Рашаант сумын Эрүүл мэндийн төв 180.0 сая төгрөг, аймгийн Эрүүл мэндийн газарт 81.6 сая төгрөг нийт 261.6 сая төгрөгийн 2 автомашин, хандив тусламжаар Сайхан, Бугат сумын эрүүл мэндийн төвд тус бүр 1 автомашины парк шинэчлэлт хийгдсэн. Хэрэгжилт 100 хувь.
	Төсөл		Хангал, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын их засвар хийх	Засварын ажлын гүйцэтгэл	хувь	-	-	100	50.0	1000.0	420.0	42	2024 онд орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хутаг-өндөр сумын эрүүл мэндийн төвийн засвар, 320.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бугат сумын эрүүл мэндийн төвийн засварын ажил хийгдэж дууссан. Хангал сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлын төсөв 400.6 сая төгрөг, Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлын төсөв 515.3 сая төгрөгийн засварын ажлуулсан саналыг орон нутгийн 2025 оны төсвийн саналд тусгасан.
	Төсөл		Эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	Тоног төхөөрөмжөөр хангалтын хувь	хувь	2022	86.3	90	90	700.0	700.0	100	2024 онд аймгийн эрүүл мэндийн салбарт улсын төсвийн 700.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэг, 16 сумдын Эрүүл мэндийн төвүүд оношилгоо, эмчилгээ, яаралтай тусламжийн нийт 18 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Тоног төхөөрөмжийн хангалтын хувь 3.7 хувиар нэмэгдэж 90.0 хувьд хүрсэн. Хэрэгжилт 100 хувь.
	Төсөл		Нэгдсэн эмнэлгийн лифт суурилуулах	Гүйцэтгэл	хувь	-	-	100	30	400.0	400.0	100	Орон нутгийн төсвийн санхүүжилтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын лифт угсралтын ажилд 400.0 сая төгрөг батлагдаж, үнэлгээний хороо байгуулагдан, тэндөр аарлагдсан байна. Хэрэгжилт 30 хувь.
1.5.1.5.	Үндсэн үйл ажиллагаа	Эрүүл мэндийн даатгал хөтөлбөр	ЭМД-ын хамрагдалтыг нэмэгдүүлэх	Нийт хүн амын хамрагдалт	хувь	2022	58	60	51.0	0.0	0.0	0	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалын дагуу 2024 онд 8862 иргэн хамруулахаар төлөвлөсөн. 2024 оны 10 дугаар сарын байдлаар хамрагдалтын төлөвлөгөө 86.0 хувьтай байна. Хэрэгжилт 90 хувь.
1.6	Салбар	ЭМЯ	Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад										
1.6.1	Хөтөлбөр	Эрүүл мэнд	Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлагыг хангасан эмийн эзлэх хэмжээг 18.7 хувьд хүргэнэ.										
1.6.1.1.	Арга хэмжээ	Эм, эмнэлгийн хэрэгсэл хөтөлбөр	Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэд	тоо	2022	500	5000	265	0.0	0.0	0	Булган Монос салбарын 5 жилийн ойд зориулсан үйл ажиллагааны үеэр 265 иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд эмийн мэдээлэл хүргэж, гарын авлага тарааж сурталчлан хамтран ажилласан. ЭМБ-уудын ОНЭМА нарт долоо хоног бүрийн давтамжит цахим сургалтаар эмийн зөв зохистой хэрэглээний талаар мэдээлэл хүргэсэн. Хэрэгжилт 30 хувь.
1.6.1.2.	Төсөл	Эм, эмнэлгийн хэрэгсэл хөтөлбөр	Эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	Тоног төхөөрөмжийн хангалт	хувь	2022	89.7	90	90	700.0	700.0	100	Аймгийн эрүүл мэндийн салбарт улсын төсвийн 700.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэг, 16 сумдын Эрүүл мэндийн төвүүд оношилгоо, эмчилгээ, яаралтай тусламжийн нийт 18 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Тоног төхөөрөмжийн хангалтын хувь 3.7 хувиар нэмэгдэж 90.0 хувьд хүрсэн. Хэрэгжилт 100 хувь.
1.7	Салбар	БТСХороо, ЭМЯ	"Хэвийн" биеийн жинтэй иргэдийн тоог 5.6 хувиар нэмэгдүүлнэ.										
1.7.1	Хөтөлбөр	Эрүүл мэнд	Өдөрт 30 минут дасгал хөдөлгөөн хийдэг иргэдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ.										
1.7.1.1.	Арга хэмжээ	Нийтийн биеийн тамир хөтөлбөр	"Сансар марафон" арга хэмжээг зохион байгуулах	Оролцсон иргэд	тоо	2022	538	1500	2000	12.8	12.8	100	Монгол хүн сансарт ниссэний 43 жилийн ой, Булганчуудын бахархлын өдрийг тохиолдуулан "Сансар марафон-2024" тэмцээнийг 12.8 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулан 34 байгууллагын 2000 гаруй иргэд тамирчин оролцлоо. Хэрэгжилт 100 хувь.
	Арга хэмжээ		"Эрүүл монгол хүн" хөдөлгөөнийг зохион байгуулах	Арга хэмжээнд оролцсон иргэд	тоо	2022	3800	5000	25500	6.3	6.3	100	Улсын хэмжээнд зохион байгуулагдсан "Цаг гаргая", Илүүдэл жингүй-Эртэн Булган аянуудыг зохион байгуулж, 9 сум, 20 байгууллагын 25500 албан хаагч иргэд өглөө бүр ахалт, гүйлт, дугуй, өглөөний дасгал, шугаман бүжиг, нийтийн бүжиг, ажлын байрны дасгал, сорил судалгаа болон бусад арга хэмжээнүүдэд идэвхтэй хамрагдав.
1.7.1.2.	Төсөл	Нийтийн биеийн тамир хөтөлбөр	Спорт заалны барилга барих	Эхлүүлсэн барилга	тоо	2022	1	1	1	320.00	314.00	98.1	Дашинчилэн сумын сургуулийн биеийн тамирын талбай байгуулах ажлыг орон нутгийн төсвийн 314.0 сая төгрөгөөр Баян-Өндөр ХХК-аар хийж гүйцэтгүүлэн хүлээн аваад байна. Хэрэгжилт 100 хувь.

1.7.1.3.	Арга хэмжээ	Мэргэжлийн спортын хөгжил хөтөлбөр	Гадаад орнуудтай хамтын ажиллагаа тогтоож, харилцан туршлага судлах	Туршлага судалсан тамирчид	тоо	2022	5	25	1	0.00	0.00	0.0	Аймгийн 16 сум 1 тосгоны биеийн тамирын багш, арга зүйчдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хойд бүсийн сургалтад 6 арга зүйчнийг оролцуулав. Мөн"Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил" судалгаа авах аргачлал тодорхойлох сургалтыг зохион байгуулж, ЕБС-ын биеийн тамирын 35 багш, арга зүйчдийг бүрэн хамрууллаа. Мөн БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан биеийн тамирын арга зүйчдийн сургалтад Биеийн тамир, спортын газрын 1 арга зүйчийг хамруулсан. Хэрэгжилт 90 хувь.
	Арга хэмжээ		Өсвөрийн шигшээ багийг амжилт гаргахад дэмжлэг үзүүлэх	Гаргасан амжилтын өсөлт	хувь	2022	87	90	48	90.00	90.00	100	Өсвөрийн шигшээ багийн бэлтгэл сургуулалт, хэрэглэл материал, тэмцээний зөрдөлд орон нутгийн төсвөөс 45.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Улс, бүс, олон улсын чанартай 31 удаагийн тэмцээн уралдаанд өсвөрийн 2294 тамирчин оролцож, 289 медаль хүртэж үзүүлсэн амжилт өмнөх оны мөн үеэс 48 хувиар өссөн үзүүлэлтэй.
	Арга хэмжээ		Улс, олон улс, тив дэлхийн хэмжээний тэмцээн уралдаанд амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулах	Урамшуулал авсан багш, тамирчид	тоо	2022	56	60	124	41.1	41.4	100	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны XX/08 дугаар тогтоолоор улс, олон улс, тив дэлхийн хэмжээний тэмцээн уралдаанд амжилт гаргасан тамирчдад, урамшуулал олгох журмыг шинэчлэн батлуулж, хагас жилийн байдлаар улс, олон улс, тив дэлхийн чанартай тэмцээнд 120 тамирчин, 4 дасгалжуулагч амжилт гарган, 41.4 сая төгрөгийн мөнгөн урамшуулал авах болзлыг хангаад байна. Хэрэгжилт 100 хувь.
	Арга хэмжээ		Улс бүсийн чанартай тэмцээн уралдааныг орон нутагтаа зохион байгуулах	Зохион байгуулсан уралдаан тэмцээн	тоо	2022	5	8	2	52.6	52.6	100	2024 онд улс, бүсийн чанартай 3 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулан орон нутгийн төсвөөс 52.6 сая төгрөг зарцууллаа. Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Г.Баатар агсны нэрэмжит өсвөрийн цанын улсын аварга шалгаруулах тэмцээнд 15 багийн 126 тамирчин, Л.Дорж агсны нэрэмжит зуун буудалт даамны улсын аварга шалгаруулах тэмцээн, Самбо бөхийн олон улсын хэмжээний мастер, дасгалжуулагч Н.Мөнхөө агсны нэрэмжит самбо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 32 багийн 420 гаруй тамирчил өрсөллөн. Хэрэгжилт 70 хувь.
1.7.1.4	Арга хэмжээ	Үндэсний уламжлалт спортын хөгжил хөтөлбөр	Үндэсний спортын тэмцээн уралдааныг олон төрлөөр зохион байгуулах	Зохион байгуулсан уралдаан тэмцээн	тоо	2022	10	8	4	49.9	49.9	100	Үндэсний спортыг хөгжүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 49.9 сая төгрөгийг зарцууллаа. Тухайлбал: Булган аймгийн харьяат "Таван аваргын нэрэмжит 128 бөхийн барилдаан"-ыг Булган суманд, "Мөнгөн өвөл-2024" арга хэмжээг Булган суманд зохион байгуулж мөсний сур, шагайн төрөлд 4 аймгийн 6 багийн 202 тамирчид, "Харгалын хүчтэний цом" үндэсний бөхийн өсвөр үе, залуучуудын нээлттэй тэмцээнд 12 байгууллагын 176 тамирчин тус тус амжилттай оролцлоо.Мөн үндэсний шагайн харвааг хөгжүүлэх зорилтын хүрээнд "Хангинахуйн шугуйн шагайн тойром" арга хэмжээнд 30 багийн 350 гаруй тамирчин, Айраг фестиваль эвент арга хэмжээнд сур, шагай, үндэсний бөхийн төрөлд 150 гаруй тамирчид, Алтаргана-2024 олон улсын наадмын 7 төрлийн спортын тэмцээн уралдаанд ОХУ, ӨМӨЗО, Дорнод, Хантий, Улаанбаатар, Дархан-Уул аймгаас 500 гаруй тамирчид, Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан ахмадын шагайн харваа улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 багийн 30 тамирчин амжилттай оролцож, эдгээр арга хэмжээнд нийт 1900 гаруй тамирчдыг хамруулав. Дээрх арга хэмжээний үр дүнд аймгийн үндэсний спортын холбооны үйлд
2.1	Салбар	ХНХЯам	Зохистой хөдөлмөр эрхэлж буй хүний тоог 40 мянгаар нэмэгдүүлнэ.										
2.1.1	Хөтөлбөр	Хөдөлмөр эрхлэлт	Албан бус хөдөлмөр эрхлэлтийг 4 хувиар бууруулна.										
2.1.1.1	Арга хэмжээ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Шинэ ажлын байрыг бүртгэж, ажиллах хүчнийг зуучлах	Шинээр ажлын байранд зуучилсан иргэд	тоо	2022	698	1400	415	0.00	0.00	0	Төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэний хөрөнгөөр оруулалтаар түр ажлын байр 411, улирлын ажлын байр 82, байнгын ажлын 411, нийт 904 шинэ ажлын байр бий болсоныг хөдөлмөр эрхлэлтийн ejob праграммд бүртгэн ажиллалаа. Аж ахуйн нэгж, иргэдээс ирсэн сул чөлөөтэй ажлын байранд хөдөлмөр эрхэлдэггүй хөдөлмөрийн насны 1165 иргэнийг ажлын байранд зуучилсан. Үүнээс байнгын ажлын байранд 587, улирлын ажлын байранд 102, түр ажлын байранд 486 иргэн тус тус ажлын байранд зочилсон байна. Хэрэгжилт 90.
	Арга хэмжээ		Хөдөлмөр эрхлэлтийн болон үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт	тоо	2022	373	1575	218	12.00	3.1	25.8	Зорилтод бүлгийн иргэдэд мэргэжил олгох арга хэмжээний хүрээнд Хангал суманд эмэгтэйчүүдэд зориулсан цахим ур чадвар олгох болон гар урлалын сургалт, Бүрэгхангай, Сайхан сумдад тогооч, Баяннуур суманд худалдагч, няравын сургалт нийт 4 удаагийн сургалтыг зохион байгуулж 96 иргэнийг сургалтад хамруулж 13 иргэний ажлын байрыг хадгалж, 31 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлан ажилласан. Мөн аж ахуй эрхлэлтийн зээлийн өмнөх сургалтыг ЭМ ЭС девелопент сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж 150 иргэнийг оролцуулсан.
2.1.1.2	Арга хэмжээ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр Үйл ажиллагаа	Хөдөлмөрийн маргаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан иргэд	тоо	2022	601	1200	141	0.0	0.0	0	Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА тухай хууль, Мэргэжлийн харилцааны талаар болон хөдөлмөрийн эрхийн маргаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 удаагийн сургалтыг зохион байгуулж, 659 ажилтан, албан хаагчийг хамруулсан. Хөдөлмөрийн эрхийн маргааныг 4 тогмлыг хүлээн авч, хуулийн дагуу шийдвэрлэж ажилласан.
	Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн байгууллагуудын хамтын гэрээг хянан, мэдээллийн санд бүртгэх		Бүртгэгдсэн хамтын гэрээ	тоо	2022	Хамтын хэлцээр -0 Хамтын гэрээ-2	Хамтын хэлцэлээр-1 Хамтын гэрээ-6	Хамтын гэрээ 3, Хамтын хэлцэлээр 14	0.0	0.0	0	Аймгийн 2022-2024 оны хөдөлмөр, нийгмийн зөвшилцөн хэлцэлийг шинэчлэн байгуулж, сумдад хүргүүлснээр 14 сум хэлэлцээрээ байгуулна ажиллаж байна. Мөн 3 аж ахуй нэгж өмнөх онд хамтыг гэрээ байгуулсан, гэрээний гуацаа дуусаагүй, хүчинтэй байна. ХАБЭА-н сарын аяны хүрээнд хөдөлмөр, нийгмийн зөвшилтийн гурван талт хороо болон сум, байгууллагын ХАБЭА-н зөвлөлийн гишүүдийн "Нэгдсэн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, 200 гаруй төлөөллийг хамруулан, хөдөлмөрийн харилцааны талаарх мэдлэг олгосон. Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзэллэрг 91 байгууллагад зохион байрлуулж байна. Хэрэгжилт 90 хувь.	
2.2	Салбар	ХНХЯам	Өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээг ажиллагчдын дундаж цалингийн 33 хувиас бууруулахгүй.										
2.2.1	Хөтөлбөр	НИЙгмийн хамгаалал	Тэтгэврийн даатгалын сангийн үлдэгдэл хөрөнгийн жилийн дундаж өгөөжийг 5 хувьд хураана.										
2.2.1.1	Төсөл	Нийгмийн даатгал хөтөлбөр	Нийгмийн даатгалын хэлтсийн архивыг цахимжуулах	Шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт	хувь	-	-	100	30	0.0	0.0	0	"Нийгмийн даатгалын газрын архивыг цахимжуулах" ажлын хүрээнд 1995-2005 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбогдох НДТ, НД8, цаасан суурьтай баримт материалыг сканнердаж цахимжуулсан. Цахимжуулснаар иргэд даатгуулалтад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа авах тохиолдолд үндсэн баримтаас бус цахимд буй баримтаас лавлагааг гаргаж өгөх боломж бүрдсэн. Хэрэгжилт 100 хувь.
3.1	Салбар	Соёлын яам	Үндэсний соёлын дорхлцаг 66 хувьд										

3.1.1	Хөтөлбөр	Соёл	Нүүдлийн соёл иргэншлийг 20 хувиар бэхжүүлнэ.																				
3.1.1.1.	Арга хэмжээ	Нийгмийн соён гэгээрэл хөтөлбөр	Соёлын биет бүс өв тээгчдийн бүртгэлжүүлэх	Шинээр нэмж бүртгэлжүүлсэн өв тээгч	тоо	2022	32	5	5	5.0	5.0	100	Соёлын биет бүс өвийг өвлөн уламжлагчийг шинээр бүртгэх ажлыг зохион байгуулж байна. Мөн шинээр бүртгүүлэх 15 өвлөн уламжлагчийн саналыг хүлээн авч, Соёлын биет бүс өвийн орон тооны бүс зөөлөгийн хулааг ажиллан шийдвэрлэхээр Бүрэгхангай сумын Дархан багийн нутагт орших Бурза толгойн хийдийн туурь, Цахт багийн нутагт орших Улаан тугалын хүрээний хийдийн туурь, Баан-Алт сумын Дулаантаан багийн нутагт орших Хадны бичээс-1, Баянуур сумын Хан-Шахайт багийн нутагт орших Хөшөө чулуу-1, Хадны сүг зураг-1, нийт 5 Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг шинээр бүртгэлжүүлсэн. Хэрэгжилт 100 хувь.										
	Арга хэмжээ		Түүхийн дурсгалт зүйлсийн хамгаалалтыг сайжруулах	Шинээр хамгаалалтанд авсан түүхийн дурсгал	тоо	2022	35	15	15	10.0	5.0	50	Соёлын бүтээлч сар-2024" ажлы хүрээнд соёлын өв, соён гэгээрэл, урлаг уран бүтээлийг онцлох 3 хүнийг таанилцуулах цуврал контент, "Алтаргана-2024" олон улсын XV их наадамд зориулан төрийн соёрхолт Ц.Чинзоригийн "Нутаг" уран бүтээл, Баян-Алт сумын Соёлын төв болон МҮОНТ-тай хамтран "Монгол өв соёл" нэвтрүүлэлт зэрэг 3 төрлийн контентыг батлан олон нийтэд хүргүүлжээ байна. Хэрэгжилт 100 хувь.										
	Арга хэмжээ		"Булган нутгийн бахархал" контент бэлтгэх	Бэлтгэсэн контент	тоо	2022	3	3	1	15.0	0.0	0											
3.1.2	Хөтөлбөр	Соёл	Нийгмийн соён гэгээрлийн түвшинг 20 хувиар нэмэгдүүлнэ.																				
